



**ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН 2023-2025 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 оны 07 дугаар сарын 17

№	Хэлэлцээрт тусгагдсан арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
1.Хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох талаар				
1.1.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр салбарт хэлэлцүүлэг зохион байгуулах замаар нийгмийн түншлэгч талууд болон гишүүдийн саналыг тусгахад хамтран ажиллана.	1.1.1. Орон сууцны ашиглалтын тухай хуулийн төслийг Засгийг газарт өргөн барих.	2023	БХБЯ
		1.1.2. Нийгмийн даатгалын багц хуулиуд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан салбарт хуулийн хэрэгжилтийг хангуулах, сурталчилахад нийгмийн түншлэгч талуудтай хамтран ажиллах.	2023	-БХБЯ -МОСНААҮА-ны ҮЭХ -"МНААҮХ" ТББ
		1.1.3. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд түншлэгч талууд болон гишүүдээс санал авч тусган холбогдох яаманд хүргүүлэх.	2023	-БХБЯ -МОСНААҮА-ны ҮЭХ
		1.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд түншлэгч талууд болон гишүүдээс санал авч тусган холбогдох яаманд хүргүүлэх.	2023	-БХБЯ -МОСНААҮА-ны ҮЭХ -"МНААҮХ" ТББ
1.2.	Салбарын ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амжиргааг дээшлүүлэхтэй холбоотой дүрэм, журам, төсөл, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үйлдвэрчний эвлэл болон салбарын мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангаж ажиллах.		2023	-БХБЯ -ХСУХАТАҮЗХ -"БХТ" ТӨААТҮГ
1.3.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын ажилтны мэргэжлийн стандарт боловсруулж, батлуулах.		2023	-БХБЯ -"БХТ" ТӨААТҮГ

1.4.	Мэргэжилтэй ажилтнуудын цалин урамшууллыг мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нормтой уялдуулан тооцох судалгааг хийж, салбарын тариф, мэргэжлийн лавлахыг боловсруулна.	1.4.1. Мэргэжилтэй ажилтнуудын цалин урамшууллыг мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нормтой уялдуулан тооцох судалгааг хийх зардлыг Барилга, байгууламжийн норм, нормативийн сангийн 2024 оны төлөвлөгөө, төсөвт тусгуулах арга хэмжээ авах.	2023	-БХБЯ -“БХТ” ТӨААТҮГ
2.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлын талаар				
2.1.	Ажлын байрыг олноор цөөрүүлэх, хөдөлмөрлөх нөхцөл байдлыг дордуулахад хүргэх орон тоо, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ аж ахуйн нэгж багууллага (ажил олгогч) нь нэг сарын өмнө салбарын болон орон нутаг дахь үйлдвэрчний эвлэлийн холбоонд урьдчилан бичгээр мэдэгдэж, ажилтны хууль ёсны ашиг сонирхлыг хангах, нийгмийн хамгааллын талаар тусгай гэрээ байгуулж, орон нутаг дахь хөдөлмөр зохицуулалтын албанд бичгээр мэдэгдэх.		2023	ОСНАА-н байгууллагууд
2.2.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг өөрчлөн зохион байгуулах, хувьчлах тохиолдолд тухайн байгууллага, аж ахуйн нэгжид ажиллаж байсан ажилтнууд, ахмадууд, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан ажилтнуудын харьяалал, нийгмийн хамгааллын асуудлыг эрх шилжүүлэн авсан байгууллага бүрэн хариуцах.		2023	ОСНАА-н байгууллагууд
2.3.	Үйлдвэрлэлийн осол, хурц хорлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтан, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг тэдний мэргэжил, ур чадвар, дадлага туршлагыг ашиглах зорилгоор эрүүл мэндэд харшлахгүй ажлын байраар хангахад ажил олгогчийн зүгээс анхаарч ажиллах.		2023	ОСНАА-н байгууллагууд
2.4.	Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагын удирдлагыг мэргэжлийн байх болон салбартаа ажилласан туршлагыг харгалзан мерит зарчмаар дэвшүүлэн тогтвортой ажиллуулах бодлого баримтална.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8.1.4-т “ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн томилж, чөлөөлөх;” гэж заасныг хэрэгжүүлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах.	2023	БХБЯ
2.5.	Хэлэлцээрийн хугацаанд дараах зөвлөгөөн, чуулган, уралдаан, тэмцээнийг талууд хамтран зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлт үр дүнг тооцож ажиллана.	2.5.1. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны улсын зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	2023	БХБЯ

		2.5.2. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийн мэргэжилтнүүдийн чуулган зохион байгуулах.	2023	"БХТ" ТӨААТҮГ
2.6.	Салбарын үйлчилгээний төлбөр төлөлтийг цахимжуулахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ салбарт нэвтрүүлэх техник, технологийн шинэчлэлтийн хүрээнд ажлын байрыг цомхтгохгүй байхад бодлогоо чиглүүлж, ажлын байраар хангаж ажиллана.	2.6.1. Салбарын үйлчилгээний төлбөр төлөлтийг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх.	2023	ХСУХАТАҮЗХ
		2.6.2. Салбарт нэвтрүүлэх техник, технологийн шинэчлэлтийн хүрээнд ажлын байрыг цомхтгохгүй байхад бодлогоо чиглүүлж, ажлын байраар хангаж ажиллах.	2023	ОСНАА-н байгууллагууд
2.7.	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын төсвийн хэмнэлт, үйл ажиллагааны нэмэлт орлогоос холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 50-иас доошгүй хувийг тухайн байгууллагын ажилтнуудын урамшуулал, нийгмийн баталгааг сайжруулахад зарцуулах журмыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, салбарын байгууллагуудад мөрдүүлж ажиллана.	2.7.1. Холбогдох журмын төсөл боловсруулах.	2023	-ХСУХАТАҮЗХ -МОСНААҮА- ны ҮЭХ
2.8.	Ажилтнуудын нийгмийн баталгааг сайжруулах, шийдвэрлэхтэй холбоотой асуудлуудыг хамтын гэрээндээ тусган шийдвэрлэх арга хэмжээг авах.		2023	-МОСНААҮА- ны ҮЭХ -ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод
2.9.	Аж ахуйн нэгж байгууллага нв ахмад настнууддаа чиглэсэн асуудлуудыг хамтын гэрээндээ тусган шийдвэрлэх арга хэмжээг авах.		2023	-МОСНААҮА- ны ҮЭХ -ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод
3.Цалин хөлс, урамшууллын талаар				
3.1.	Салбарын эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулах бодлогын хүрээнд үнэ тариф, үйлчилгээний хөлсийг зах зээлийн үнэтэй уялдуулан нэмэгдүүлэх саналыг боловсруулж, батлуулах.		2023	ХСУХАТАҮЗХ
3.2.	Нийтийн аж ахуйн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь тухайн онд Үндэсний статистикийн хорооноос* жил бүр тогтоосон бүс нутгийн амьжиргааны баталгаажих доод түвшинг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байх бөгөөд цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох талууд хамтран ажиллах.		2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА- ны ҮЭХ -ҮЭХороод
3.3.	Тасралтгүй ажиллагаатай аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын байранд ээлжээр ажилладаг ажилтнуудад шөнийн цаг, баяр ёслолын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг Хөдөлмөрийн тухай		2023	-ОСНАА-н байгууллагууд

	хуульд заасан хувь хэмжээнээс нэмэгдүүлэн олгох талаар хамтын гэрээндээ тусган шийдвэрлэх арга хэмжээг авах.			-МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
3.4.	Бохир усны төвлөрсөн систем болон цэвэрлэх байгууламжид ажилладаг ажилтны үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлж олгоно. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээгээр хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа нь тогтоогдсон ажлын байруудад олгох нэмэгдлийг хамтын гэрээндээ тусган шийдвэрлэх арга хэмжээ авна.	3.4.1. Бохир усны төвлөрсөн систем болон цэвэрлэх байгууламжид ажилладаг ажилтны үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлж олгох. 3.4.2. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээгээр хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа нь тогтоогдсон ажлын байруудад олгох нэмэгдлийг хамтын гэрээндээ тусган шийдвэрлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
3.5.	Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн ашиг, хөдөлмөрийн бүтээмж, үнэ тарифын өсөлт, мэргэжлийн зэрэг, ур чадвар, дадлага, туршлага, тогтвор суурьшил, ажилласан жил зэргийг харгалзан салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа цалин, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох.		2023	-БХБЯ -ХСУХАТАҮЗХ -“МНААҮХ” ТББ -МОСНААҮА-ны ҮЭХ
3.6.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт тасралтгүй ажиллаж байгаа ажилтны удаан жил ажилласан хугацааны нэмэгдлийг 2 жил тутамд нэмэгдүүлэн тооцож, хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажилладаг ажилтанд албан тушаалтын болон үндсэн цалингийн 35 хүртэл хувь, хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд 40 хүртэл хувийн шатлалтайгаар нэмэгдүүлэн бодож олгоно.	3.6.1. Тасралтгүй ажиллаж байгаа ажилтны удаан жил ажилласан хугацааны нэмэгдэл тооцох хугацааг хамтын хэлэлцээртэй уялдуулан хамтын гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулан батлах 3.6.2. Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажилладаг ажилтанд албан тушаалтын болон үндсэн цалингийн 35 хүртэл хувь, хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд 40 хүртэл хувийн шатлалтайгаар нэмэгдүүлэн бодож олгохыг хамтын гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулан батлах.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
3.7.	Аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 хүртэл сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний	3.7.1. Тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 хүртэл сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллын санг байгуулах.	2023	ОСНАА-н байгууллагууд

	урамшууллын санг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хуримтлуулж ажиллана. Тухайн ажилтан, албан хаагчийн жилийн ажлын үр дүнг харгалзан 3 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг тогтоосон санд багтаан олгож болно.	3.7.2. Тухайн ажилтан, албан хаагчийн жилийн ажлын үр дүнг харгалзан 3 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг тогтоосон санд багтаан олгох.		
3.8.	Сарын үр дүнгийн шагналыг тухайн сарын үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, аюулгүй ажиллагаа, борлуулалтын орлого төвлөрүүлэлт, зардлын хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, үр дүнд үндэслэн тухайн хамт олны албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож олгох.		2023	ОСНАА-н байгууллагууд
3.9.	Оновчтой санал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар зардал хэмнэсэн тохиолдолд хэмнэлтийн 20 хүртэлх хувиар тооцон урамшуулал олгох..		2023	ОСНАА-н байгууллагууд
3.10.	Зөвлөх инженер албан тушаалын 20 хувь, мэргэшсэн инженер, мэргэшсэн нягтлан бодогчид үндсэн цалингийн 15 хувьтай, ахлах зэрэгтэй ажилтанд үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшууллыг албан тушаал харгалзахгүйгээр олгох.		2023	ОСНАА-н байгууллагууд
3.11.	Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулж ногдуулахгүй байх зарчмаар сар болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг ногдох хувиар олгох.		2023	ОСНАА-н байгууллагууд
3.12.	Ажилтнууд мэргэжлийн түвшингээ дээшлүүлэх, шинээр мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдахад сургалтын хугацаанд албан тушаалын цалинг бүрэн олгох.		2023	ОСНАА-н байгууллагууд
3.13.	Тэтгэвэрт гарах судалгаанд хамрагдаж, тэтгэмжийн зардал нь тухайн жилийн төсөв, төлөвлөгөөнд тусгагдсан ажилтан тэтгэвэр тогтоолгохоос өмнө нас барсан тохиолдолд төлөвлөгдсөн тэтгэмжийн зардлын 50 хувийг гэр бүлд нь олгох асуудлыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлэх.		2023	-МОСНААҮА-ны ҮЭХ -ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод
4.Нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар				
4.1.	Улсын хэмжээнд ажил мэргэжлийн ангилал зэрэглэл шинэчлэгдэж байгаатай холбогдуулан салбарын ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэхэд салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.		2023	БХБЯ
4.2.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын тулгамдсан асуудлуудаар талууд харилцан зөвлөлдөх, мэдээлэл солилцох, хамтын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.		2023	БХБЯ МОСНААҮА-ны ҮЭХ
4.3.	Монгол Улсын хэмжээнд орон сууц, нийтийн аж ахуйн салбарын ажилтнуудын суурь судалгааг нэгтгэж, мэдээлэл, судалгааны баазыг бүрдүүлнэ.	4.3.1. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын ажилтнуудын суурь судалгаа хийх.	2023	-БХБЯ -МОСНААҮА-ны ҮЭХ
4.4.	Ажилтнууддаа өөрийн цайны газраар дамжуулан өдрийн хоолыг өөрийн өртгөөр олгох, эсвэл үнийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлэх.		2023	-ОСНАА-н байгууллагууд


			-МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
4.5.	Ажилтнуудын ажилдаа ирж, очих унааны зардал, унааны хөнгөлөлтийн асуудлыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
4.6.	Халаалтын улиралд олгох хөнгөлөлтийг нэг зуун мянган төгрөгөөс доошгүй байхаар бодож жилд нэг удаа олгох. /Энэ заалт Үйлдвэрлэлийн осол, Мэргэжлээс шалтгаалах өвчний групптэй хүмүүс, хүүхэд асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд нэг адил хамаарна/	2023	ОСНАА-н байгууллагууд
4.7.	Хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтанд чөлөөний хугацаанд нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгох.	2023	ОСНАА-н байгууллагууд
4.8.	Ажилтны төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд нас барахад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлэх. /Нэг байгууллагад гэрбүлийн болон ахан дүүс, хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд олгоно/	2023	ОСНАА-н байгууллагууд
4.9.	Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлд өртөж орон гэргүй болсон, эд хөрөнгийн хохирол учирсан ажилтанд хохирлын хэмжээг харгалзан үзэж нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх асуудлыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
4.10.	Ажилтан зуурдаар болон өвчний улмаас нас барвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох.	2023	ОСНАА-н байгууллагууд
4.11.	Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь ажилтнуудыг орон сууцжуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гаргах асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
4.12.	Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь ажилтнуудыг орон байрны нөхцлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гаргах асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
4.13.	Салбарын ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, тэдний хөдөлмөр бүтээлийг олон нийтэд сурталчлах, төрийн одон медалиар шагнуулах асуудлыг үе шаттайгаар зохион байгуулах.	2023	ОСНАА-н байгууллагууд

4.14.	Аж ахуйн нэгж, байгууллагын нэрийн өмнөөс олон улс, улс, салбарын чанартай биеийн тамир, урлаг, уран сайхны тэмцээн, уралдаанд оролцон амжилт гаргасан ажилтныг хамтын гэрээнд тусган шагнаж урамшуулах.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ -Салбар ҮЭХороо	
4.15.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгохтой холбоотой хэлэлцэгдэх хуулийн төсөл, тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ	
4.16.	Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааг салбарт сурталчлах, хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллах.	2023	-БХБЯ-ны Жендэрийн салбар хороо -МОСНААҮА-ны ҮЭХ	
4.17.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах, барилга, байгууламжийн зураг төсөлд холбогдох норм, дүрэм, стандартуудыг тусган хэрэгжүүлж байх, хуучин барилгын орц, гарц болон бусад дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, ашиг, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах ажлыг зохион байгуулах.	2023	-БХБЯ -ОСНАА-н байгууллагууд -МОСНААҮА-ны ҮЭХ	
4.18.	Ахмад настны тухай хуулийн 1.1, 2.1, 9.6, 9.8, 12.1, 14.6, 14.7 заалтууд, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам", Ахмадын холбооны дүрмийн 4.3, 4.5, 8.6 дахь заалтыг тус тус үндэслэн жил бүр ахмадуудтай холбоотой зардлыг баталж, хэрэгжүүлэх.	2023	ОСНАА-н байгууллагууд	
5. Ажилтнуудын мэргэжил, боловсролын талаар				
5.1.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын Мэргэжил, сургалтын төвийг нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын дэргэд байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ.	5.1.1. Шаардагдах хөрөнгө оруулалтын зардлыг улсын 2024 оны төсөвт тусгуулах саналыг ЭЗХЯ-нд хүргүүлж шийдвэрлүүлэх.	2023	БХБЯ
5.2.	Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас зохион байгуулж байгаа сургалт, семинар болон жагсаал, цуглаан бусад үйл ажиллагаанд ажилтнуудыг саадгүй хамруулан оролцуулах.		2023	ОСНАА-н байгууллагууд
5.3.	Ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллага хамтран тухайн жилд нийт ажилтнуудын 30-аас доошгүй хувийг мэргэжлийн чиглэлээр чадавхжуулах сургалтанд хамруулах бөгөөд талууд хамтарсан сургалтын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж, хэрэгжүүлэх.		2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод
5.4.	Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 20.3 дахь хэсгийн дагуу ажил олгогчнь мэргэжилтэй ажиллах хүчний чадавхийг дээшлүүлэх зорилгоор Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл болон Салбар зөвлөлийн тогтоосон хувь хэмжээгээр дэмжлэг үзүүлэхийг хамтын гэрээндээ		2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод

	тусгаж хэрэгжүүлэх.		
5.5.	Орон нутаг дахь нийтийн аж ахуйн байгууллагуудыг инженер, техникийн ажилтнаар хангах зорилгоор мэргэжлийн их, дээд сургууль, коллежуудтай хамтран ажиллахыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -"МНААҮХ" ТББ -МОСНААҮА-ны ҮЭХ -ҮЭХороод
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар			
6.1.	Жил бүрийн 4 дүгээр сард багтаан III зэрэглэлээс доошгүй түвшний эрүүл мэндийн байгууллагад ажил, мэргэжлийн онцлогт тохирсон нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд нийт ажилтнуудаа хамруулж, гарах зардлыг ажил олгогч бүрэн хариуцах.	2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод
6.2.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор салбарын төсвийн байгууллагууд нь тухайн жилд батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй, аж ахуйн нэгж байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулж төсөвтөө тусган батлуулж, хэрэгжүүлэх.	2023	ОСНАА-н байгууллагууд
6.3.	Шаардлагатай ажлын байруудад хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийг бууруулах арга хэмжээг жил бүр авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ, анагаах үр нөлөөтэй орон нутгийн рашаан сувиллын газартай хамтран ажиллаж, сувилуулагчдад хөнгөлөлт үзүүлэх талаар гэрээ байгуулсан ажиллана.	2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод
6.4.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар салбарын хэмжээнд зөвлөгөөнийг талууд хамтран зохион байгуулах ба ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх зорилт тавин ажиллах.	2023	-“БХТ” ТӨААТҮГ -МОСНААҮА-ны ҮЭХ -ОСНАА-н байгууллагууд
7. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар			
7.1.	Монгол улсын Засгийн газрын 2013 оны “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 370, /Засгийн газрын 2019 оны 386 тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/ дугаар тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлэх.	2023	БХБЯ МОСНААҮА-ны ҮЭХ

7.2.	Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хуулиудаар баталгаажсан хөдөлмөрийн харилцаан дахь нийгмийн түншлэл, түүний зарчмуудыг мөрдөж, Барилга, хот байгуулалтын яамны дэргэд “Салбарын хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо” болон цалин хөлсний хороодтой болох асуудлыг судалж, салбарын сайдын дэргэдэх ХАБЭА-н салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулна.	7.2.1. Барилга, хот байгуулалтын яамны дэргэд “Салбарын хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо” болон цалин хөлсний хороодтой болох асуудлыг судлах.	2023	БХБЯ
		7.2.2. ХАБЭА-н салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах.	2023	БХБЯ
7.3.	Аж ахуйн нэгж байгууллагын захирал (дарга)-ын зөвлөл байгууллагын бүтэц зохион байгуулалт, ажилтнуудын ажлын байрны өөрчлөлт, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, шагнал урамшуулал, сахилгын шийтгэл зэргийг хэлэлцэхэд үйлдвэрчний эвлэлийн хорооны даргыг зөвлөх эрхтэйгээр оролцуулах.	2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод	
7.4.	Ажил олгогч нь үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээ хэлэлцээрт тусгагдсан сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах нөхцлөөр хангах.	2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод	
7.5.	Үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас тавьсан аливаа санал, гомдол, хүсэлтийг бичгээр хүлээн авч хэлэлцэж, зөвшилцөх замаар шийдвэрлэх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод	
7.6.	Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд заасан эрх, баталгааг хангахын зэрэгцээ ажил олгогч нь аж ахуйн нэгж байгууллагын эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны талаарх шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх.	2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод	
7.7.	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь ажил олгогчтой хамтран хамтын гэрээ, хэлэлцээр хийх, батлах, явц үр дүнг хэлэлцэж, хэрэгжилтийг нийт гишүүдэд жил тутам танилцуулж ажиллах.	2023	-ОСНАА-н байгууллагууд -ҮЭХороод	
8. Хэлэлцээрийн биелэлтийг дүгнэх талаар				
8.1.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж ажиллана.	8.1.1. Хамтын хэлэлцээрт хамрагдсан ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлийн хороо нь хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг (Хамтын хэлэлцээрийн хавсралт-1 ийн дагуу) хамтран гаргаж дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Барилга, хот байгуулалтын яам, Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоонд ирүүлэх.	2024	-ОСНАА-н байгууллага -ҮЭХороод

	8.1.2. Монголын орон сууц, нийтийн аж ахуйн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо нь салбарын хэмжээнд хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж, 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор биелэлтийг хамтран хэлэлцэж, дүгнэх.	2024	-БХБЯ -ХСУХАТАУЗХ -"БХТ" ТӨААТҮГ -МОСНААҮА- ны ҮЭХ -"МНААҮХ" ТББ
	8.1.3. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хамтын хэлэлцээр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, үр дүнг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороонд 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлэх.	2024	-БХБЯ -МОСНААҮА- ны ҮЭХ -"МНААҮХ" ТББ

Барилга, хот байгуулалтын яамны
Барилга, инженерийн дэд бүтцийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

Д.ГАНТУЛГА-р

Монголын орон сууц, нийтийн аж ахуйн
үйлчилгээний ажилтны үйлдвэрчний
эвлэлийн холбооны дэд дарга


Ш.СОДНОМЦЭРЭН

"Монголын нийтийн аж ахуйн
үйлчилгээний холбоо" ТББ-ын
гүйцэтгэх захирал


Б.АЛТАНТУУЛ

* Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан Хүн амын амьжиргааны доод түвшин

Бүс	Тогтоосон амьжиргааны доод түвшин
Баруун	274,400
Хангай	282,500
Төв	272,300
Зүүн	271,800
Улаанбаатар	313,400